

# Жагсаал

Хоёр салаа цэрэг жагсаалд гарч байв. Салаан дарга нар нь хоёр жагсаалаа нэгтгэх дүрэм гаргажээ. Хоёр салаа өөд өөдөөсөө эсрэг чиглэлд жагсах бөгөөд хугацааны эхний эгшинд ( $t=0$ ) салаа бүрийн эхний нэг цэрэг өөд өөдөөсөө харан тулж зогсоно. Түүнээс хойш секунд тутамд өөдөөс нь 2-р салааны цэрэг тулж ирсэн 1-р салааны цэрэг бүр дээгүүр нь харайж байраа солино.  $T$  секундын дараах нийлсэн жагсаалын дарааллыг гаргаарай.

## Оролт:

Эхний мөрөнд харгалзан нэг, хоёрдугаар салааны цэргийн тоо болох  $x_1$ ,  $x_2$  хоёр бүхэл тоо нэг хоосон зайтай өгөгдөнө.

Дараагийн хоёр мөрөнд харгалзан эхний болон хоёр дахь салааны (эхний цэргээс сүүлчийнх хүртэл дарааллаар) жагсаалын дарааллыг агуулна. Цэрэг бүр нь англи цагаан толгойн том үсгээр үл давхцах байдлаар тэмдэглэгддэг (энэ тэмдэглэгээ нь хоёр салааны хувьд ялгаатай байдаг).

Оролтын сүүлчийн мөрөнд бүхэл тоо  $T$  ( $0 \leq T \leq 50$ ) байна.

## Гаралт:

Нийлсэн жагсаалын дараалал  $T$  секундын дараа ямар байхыг нэг мөрөнд гаргаарай.

## Example

### Input:

3 3

ABC

DEF

0

### Output:

CBADEF

### Input:

3 3

ABC

DEF

2

**Output:**

CDBEAF